



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 1/68

Улаанбаатар хот

Хамтарсан зохицуулах зөвлөл  
байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Сангийн сайдын "Журам батлах тухай" 2021 оны 4 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын 7.10.5 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны яам, Японы Олон Улсын хамтын ажиллагаа /JICA/-ын хооронд 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан Хамтын ажиллагааны санамж бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төслийн Хамтарсан зохицуулах зөвлөлийг хавсралтаар байгуулсугай.

2. Төслийн хэрэгжилтийн талаар холбогдох талыг оролцоо, мэдээллээр хангаж, ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хамтарсан зохицуулах зөвлөлийн дарга /Л.Цэдэвсүрэн/-д үүрэг болгосугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

Боловсрол, шинжлэх ухааны сайдын  
2022 оны 02 дугаар сарын 25-ний  
өдрийн 168 дүгээр тушаалын хавсралт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТӨСЛИЙН  
ХАМТАРСАН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

Дарга	Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга
Дэд дарга	Боловсрол, шинжлэх ухааны яамны Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
Гишүүд	Боловсрол, шинжлэх ухааны яамны Гадаад харилцаа хамтын ажиллагааны газрын дарга Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Боловсрол, шинжлэх ухааны яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга Боловсролын ерөнхий газрын дарга Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газрын дарга Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэд дарга Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Үйлдвэрлэл, технологийн сургуулийн захирал Жайка олон улсын байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газрын дарга Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн удирдлага
Нарийн бичгийн дарга	Боловсрол, шинжлэх ухааны яамны Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга

...oo0oo...